



НИЙСЛЭЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 01/02

Улаанбаатар хот

Минжний хоол тэжээл нийлүүлэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/322 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Минжний хоол тэжээл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Ц.Цолмонбаатар	Биологийн олон янз байдлыг хамгаалах хэлтсийн дарга
Гишүүд	Ж.Батзолбоо	Түгээмэл тархацтай ашигт малтмал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Р.Дуламжав	"Нийгмийн хөгжлийн ертөнц" НҮТББ /зөвшилцсөнөөр/
	Г.Төмөрмөнх	"Ногоон соёл иргэншил хөгжил сан" ТББ /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Г.Нацаг	Ой хамгаалал хариуцсан мэргэжилтэн

2. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулахыг үнэлгээний хороо (Ц.Цолмонбаатар)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтэс (Б.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Р.ЭНХТАЙВАН

1150010034



**“МИНЖНИЙ 2024 ОНЫ ХООЛ ТЭЖЭЭЛ НИЙЛҮҮЛЭХ” БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Улаанбаатар хот

1	Үндэслэл дугаартай “Минжний 2024 оны хоол тэжээл нийлүүлэх” тендер
2	Байршил	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 20-р хороо, Гачуурт тосгон, хотын төвөөс 30 км зайд байрлах Минж үржүүлэх, нутагшуулах төв.
3	Хийж гүйцэтгэх ажил	Минжний 2024 оны хоол тэжээл нийлүүлэх тендерт бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу хүргэж өгөх.
4	Ажил гүйцэтгэх үе шат, хугацаа	2024 оны 3 дугаар сараас 2025 оны 2 дугаар сарыг дуустал батлагдсан хуваарийн (Хавсралт 1 хуудас) дагуу сард 2-3 удаа нийлүүлнэ.
5	Минжний хоол тэжээл, нийлүүлэх хэмжээ	Нийт хоол тэжээлийн хэмжээг 42 бодгаль минжээр тооцно. Нэг минжний идэш тэжээлийг тооцохдоо Шинжлэх ухааны Биологийн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлын 2014 оны 05-р тогтоолоор баталсан нормативыг баримтална. (Хавсралт 2 хуудас) 1. Монгол лууван – 25,771.2 кг 2. Алим – 8,248.8 кг 3. Багсармал тэжээл – 8,769.6 кг 4. Улаан буудай – 9,282 кг 5. Витамин E2000 – 9 кг
6	Нийлүүлэх хоол тэжээлд тавигдах шаардлага	1. Монгол лууван - <i>Дотоод байдал:</i> Нягт, шүүслэг байх - <i>Гадаад байдал:</i> 1 ширхэг луувангийн дундаж жин 100-200 гр, бүтэн, цэвэр, шинэ гөлгөр, зөв хэлбэртэй, эрүүл, навчин шилбэ нь 2 см-ээс илүүгүй тайрагдсан байх - Механик гэмтэлгүй - Ургамлын өвчлөлгүй - Шороо 1% хүртэл - Чанар, хэвийн байдлаа алдаагүй, зөөлөрч хөгцрөөгүй байх - Гадна гэмтэл, нөлөөнөөс хамгаалсан зориулалтын сав, баглаа боодолтой байх - Хор судлал, нян судлалын лабораторийн шинжилгээнд тогтмол хамруулах ажлыг захиалагч талын хяналтад гүйцэтгэх.

		<p>2. Алим Хятадаас бусад орны алим байх бөгөөд стандартын шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээтэй байх</p> <ul style="list-style-type: none"> - Гадаад байдал: бүтэн, цэвэр, шинэ гөлгөр, нэр төрөл, ангилалдаа тохирсон амт, үнэртэй байх - Дотоод байдал: Нягт шүүслэг бөгөөд ислэг чанар өндөр байх - Механик гэмтэлгүй - Өвчин хорогдолгүй - Чанар хэвийн байдлаа алдаагүй байх - Стандарт шаардлага хангасан зориулалтын сав, баглаа боодолтой байх - Хадгалах горимд өөрчлөлт ороогүй байх бөгөөд зэрлэг амьтны генийн олон янз байдалд сөргөөр нөлөөлөхөөргүй байх - Хор судлал, нян судлал болон ислэгийн хэмжээг лабораторийн шинжилгээнд тогтмол хамруулах ажлыг захиалагч талын хяналтад гүйцэтгэх. <p>3. Багсармал тэжээл</p> <ul style="list-style-type: none"> - Дотоод байдал: Тэжээл нь нягт шахалттай байх - Гадаад байдал: Ус чийгэнд ногоогүй, элдэв гаж үнэргүй, муудаж хөгцрөөгүй - Механик гэмтэлгүй - Бусад гадна хольцгүй байх - Чанар, хэвийн байдлаа алдаагүй, сав баглаа боодол бүрэн бүтэн байх - Стандарт шаардлага хангасан зориулалтын сав, баглаа боодолтой байх - Ашиглалтын хугацаа дуусаагүй байх. <p>4. Улаан буудай</p> <ul style="list-style-type: none"> - Дотоод байдал: Тэжээл нь нягт шахалттай байх - Гадаад байдал: Том ширхэгтэй, чийглэгийн хэмжээ стандарт шаардлага хангасан, цардуул, цавуулаг байдал хэвийн байх - Усанд ногоогүй, элдэв гаж үнэргүй, муудаж хөгцрөөгүй байх - Гадна бусад хольцгүй (шороо, чулуу, зэрлэг ургамлын үр гэх мэт) - Бутарч үйрээгүй байх - Зориулалтын сав, баглаа боодолтой, бүтэн байх - Чанар, хэвийн байдлаа алдаагүй байх. <p>5. Витамин E2000</p> <ul style="list-style-type: none"> - Дотоод байдал: Нунтаг хэлбэртэй, стандарт шаардлага хангасан байх - Гадаад байдал: Зориулалтын савалгаатай, сав баглаа боодолтой байх - Үйлдвэрийн зориулалтын савалгаатай амсрыг битүүмжилсэн, ашиглалтын хугацаа дуусаагүй байх.
7	Бараа нийлүүлэх	<p>Барааг улирлын норм хэмжээ, батлагдсан хуваарийн дагуу хүргэж өгөхөд дараах арга хэмжээг авна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Барааг нэг бүрчлэн шалгаж хүлээлцэх

		<ul style="list-style-type: none"> - Бараа бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл ахуй лабораторийн шинжилгээний дүн бүхий бичгийг хүргэлт тус бүрд захиалагчид өгөх - Барааг цэвэр жингээр тооцож тэмдэглэл хөтлөх - Бараа хүлээлцсэн актыг газар дээр нь үйлдэх - Стандартын шаардлага хангахгүй болон тээвэрлэлтийн явцад гэмтэл, гологдол үүссэн бүтээгдэхүүнийг цаг тухай бүрд нь акт үйлдэж, 1 хоногт багтаан солиулна - Зарим тохиолдолд минжний эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилгоор хоол тэжээлийн бүрэлдэхүүн болон норматив хэмжээг лабораторийн шинжилгээнд үндэслэн түр хугацаанд өөрчлөх, түүнд үүссэн зөрүүг захиалгагч талын хүсэлтээр 5 нэр төрлийн аль нэг бүтээгдэхүүнээр нөхөн орлуулах.
8	Хяналт шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай тохиолдолд нийлүүлсэн бараа бүтээгдэхүүнийг шинжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцна - Чанаргүй бараа нийлүүлсэн тохиолдолд шинэ бараагаар солиулж, захиалагчид учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ - Нийлүүлсэн чанаргүй хоол тэжээлээс болж минж хорогдсон нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан тохиолдолд нийлүүлэгч тал хохирлыг бүрэн барагдуулна - Гол үерлэсэн болон хөлдсөн, цас их хэмжээгээр унасан үед 5 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гэмтэлгүй нийлүүлэх асуудлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна - Захиалагч талаас тавьсан бусад шаардлагыг биелүүлж ажиллана.
9	Автомашин, техник тоног төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> - Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж гэрээт ажилд ашиглах туулах чадвартай авто машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг фото зургаар баталгаажуулж ирүүлэх - Барааг нийлүүлэх тээврийн хэрэгсэл нь бараа бүтээгдэхүүнийг ачих, жолоочийн хэсэг нь бараа тээвэрлэх стандарт шаардлага хангасан байна - Хавар, зуны улиралд зарим хоол тэжээлийг хадгалах зориулалтыг агуулахтай байх (шинэ ургацын хүнсний ногоо гарах хүртэл).
10	Захиалагч (хөрөнгө оруулагч) байгууллага	Нийслэлийн Байгаль орчны газар

Хянасан:

НБОГ-ын Биологийн олон янз байдлыг хамгаалах хэлтсийн дарга

Ц.Цолмонбаатар

Боловсруулсан:

НБОГ-ын БОЯБХХ-ийн ахлах мэргэжилтэн

Т.Чингэл

2024 ОНЫ МИНЖНИЙ ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА



№	Сар	Хоног	Минжний тоо	Монгол дууван			Алим			Улаан буудай			Батсармал тэжээл			Витамин Е 2000		Нийт дүн /төг/
				Хэмжээ /кг/	нэг минжинд ноогдох хэмжээ /кг/	Нийт үнэ /төг/	Хэмжээ /кг/	нэг минжинд ноогдох хэмжээ /кг/	Нийт үнэ /төг/	Хэмжээ /кг/	нэг минжинд ноогдох хэмжээ /кг/	Нийт үнэ /төг/	Хэмжээ /кг/	нэг минжинд ноогдох хэмжээ /кг/	Нийт үнэ /төг/	Хэмжээ /кг/	Нийт үнэ /төг/	
1	III	31	42	2,343.6	1.8	6,022,262.2	781.2	0.6	4,687,200.0	911.4	0.7	911,400.1	911.4	0.7	5,468,400.0	1.5	150,000.0	17,239,262.3
2	IV	30	42	2,268.0	1.8	5,827,995.7	756.0	0.6	4,536,000.0	882.0	0.7	882,000.1	882.0	0.7	5,292,000.0	1.5	150,000.0	16,687,995.8
3	V	31	42	2,343.6	1.8	6,022,262.2	781.2	0.6	4,687,200.0	911.4	0.7	911,400.1	911.4	0.7	5,468,400.0	1.5	150,000.0	17,239,262.3
4	VI	30	42	1,764.0	1.4	4,532,885.5	504.0	0.4	3,024,000.0	504.0	0.4	504,000.1	378.0	0.3	2,268,000.0	-	-	10,328,885.6
5	VII	31	42	1,822.8	1.4	4,683,981.7	520.8	0.4	3,124,800.0	520.8	0.4	520,800.1	390.6	0.3	2,343,600.0	-	-	10,673,181.8
6	VIII	31	42	1,822.8	1.4	4,683,981.7	520.8	0.4	3,124,800.0	520.8	0.4	520,800.1	390.6	0.3	2,343,600.0	-	-	10,673,181.8
7	IX	30	42	1,764.0	1.4	4,532,885.5	504.0	0.4	3,024,000.0	504.0	0.4	504,000.1	378.0	0.3	2,268,000.0	-	-	10,328,885.6
8	X	31	42	2,343.6	1.8	6,022,262.2	781.2	0.6	4,687,200.0	911.4	0.7	911,400.1	911.4	0.7	5,468,400.0	-	-	17,089,262.3
9	XI	30	42	2,268.0	1.8	5,827,995.7	756.0	0.6	4,536,000.0	882.0	0.7	882,000.1	882.0	0.7	5,292,000.0	-	-	16,537,995.8
10	XII	31	42	2,343.6	1.8	6,022,262.2	781.2	0.6	4,687,200.0	911.4	0.7	911,400.1	911.4	0.7	5,468,400.0	1.5	150,000.0	17,239,262.3
11	I	31	42	2,343.6	1.8	6,022,262.2	781.2	0.6	4,687,200.0	911.4	0.7	911,400.1	911.4	0.7	5,468,400.0	1.5	150,000.0	17,239,262.3
12	II	31	42	2,343.6	1.8	6,022,262.2	781.2	0.6	4,687,200.0	911.4	0.7	911,400.1	911.4	0.7	5,468,400.0	1.5	150,000.0	17,239,262.3
Бүгд				25,771.2	1.8	66,223,299.1	8,248.8	0.6	49,492,800.0	9,282.0	0.7	9,282,000.9	8,769.6	0.7	52,617,600.0	9.0	900,000.0	178,515,700.0

Хянасан:
 БОЯБХХ-ийн дарга
 Ц.Цолмонбаатар

Боловсруулсан:
 БОЯБХХ-ийн ахлах мэргэжилтэн
 Т.Чингэл